



ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 10 дугаар сарын 14

№ 18

Улаанбаатар хот

ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ-ээс

Захирлын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн хурал 100 хувийн ирцтэй цахимаар хуралдаж Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг даргалав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. ERP системийн танилцуулга, явц, шийдэх асуудлууд.
2. Нэгдсэн менежментийн тогтолцооны магадлан аудитын тайланг танилцуулах.
3. Компанийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг холбогдох журмын дагуу дуудлага худалдаагаар худалдан борлуулсан ажлын танилцуулга хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. ERP системийн танилцуулга, явц, шийдэх асуудлууд.
 - 1.1 ERP систем нэвтрүүлэхтэй холбоотой баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулаагүй албан тушаалтан, ажилтны жагсаалтыг гарган шалтгаан нөхцөлийг тодорхойлж, танилцуулахыг Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Х.Нурлат, Захиргаа, удирдлагын газрын дарга Х.Батсайхан нарт үүрэг болгов.
 - 1.2 ERP системийг нэвтрүүлэхтэй уялдан нэвтрүүлэх программ хангамж, дэд системийг хариуцсан албан тушаалтан, ажилтны нэрсийг жагсаалтаар гаргаж танилцуулахыг Программ хангамжийн албаны дарга Б.Атарцэцэгт үүрэг болгов.
 - 1.3 ERP систем нэвтрүүлэхтэй холбоотой дэд систем хүлээлцэх материалд гарын үсэг зурхаас татгалзсан ажилтны өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурах зохион байгуулалт хийж, татгалзсан ажилтанд журмын дагуу хариуцлага тооцож ажиллахыг Захиргаа, хууль эрх зүй хариуцсан дэд захирал Б.Батсайхан, Программ хангамжийн албаны дарга Б.Атарцэцэгт үүрэг болгов.
2. Компанийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг холбогдох журмын дагуу дуудлага худалдаагаар худалдан борлуулсан ажлын танилцуулга.
 - 2.1 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн дуудлага худалдаагаар худалдан авах хүсэлт ирээгүй 10 автосамосвалыг "Дуудлага худалдаа зохион байгуулах журам"-д заасны дагуу анхны үнийг 40 хувиар бууруулан дахин дуудлага худалдаа зохион байгуулахыг "Эд хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулах комисс"-ын дарга Х.Батсайханд үүрэг болгов.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ГАНХУЯГ

3900000028